



**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА**

2017 оны 8 дугаар сарын 30

№ 01/70 УАГ-ГАГ/2017/08-ГА

Мандалговь хот

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх заалтыг үндэслэн Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу Үндэсний аудитын газрын нэгдсэн удирдамжаар “Нэмэгдсэн өртгийн албан татварын буцаан олголтын хэрэгжилт, үр дүн”-д гүйцэтгэлийн аудит хийх явцад аймгийн барилгын материал борлуулдаг 8 /хавсралт дахь нэр бүхий/ дэлгүүр стандартын кассын машин суурилуулаагүй, төлбөрийн баримт хэвлэж өгөөгүй, зөрчил арилгах талаар өгсөн татварын албаны шаардлагыг хэрэгжүүлээгүй байна. Дээрх зөрчилд Татварын хэлтсээс Зөрчлийн тухай хуулийн дагуу 12,000,000.00 /Арван хоёр сая/ төгрөгөөр торгох, зөрчлийг арилгах дараагийн арга хэмжээг аваагүй байна.

Энэ нь Татварын Ерөнхий хуулийн 18.1.8-д /Монгол Улсын стандартын шаардлага хангасан кассын машин хэвлэх төхөөрөмж, хэвлэлийн хор, тасалбарын цаас, пос терминал машин хэрэглэх/, Зөрчлийн тухай хуулийн 11.19-ийн 6.5-д /Монгол Улсын стандартын шаардлага хангасан кассын машин хэвлэх төхөөрөмж, хэвлэлийн хор, тасалбарын цаас, пос терминал машин хэрэглэх үүргээ биелүүлээгүй бол хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно./ гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т /Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих/, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дүрмийн 2.2.3-т /Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжээч, аудитор, шинжээч нь аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах, зөрчлийг арилгуулах зорилгоор төлбөрийн акт, албан шаардлага өгөх/, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журмын 4.1.7-д /Хууль тогтоомж зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож давтан гаргуулахгүй байх нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал/, гэж заасныг тус тус үндэслэн ШААРДАХ НЬ:

1. Татварын албан шаардлагыг хэрэгжүүлээгүй иргэн, аж ахуй нэгж, байгууллагыг Зөрчлийн тухай хуулийн дагуу арга хэмжээ авч торгуулийн төлбөрийг орон нутгийн төсөвт төвлөрүүлж, зөрчлийг арилгуулах, давтан гаргахгүй байхад анхаарч ажиллах;


2. Татварын ерөнхий хууль болон Зөрчлийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавин аймгийн хэмжээнд иргэн, аж ахуй нэгж, байгууллагад холбогдох хууль, журмын талаар сургалт сурталчилгаа хийх;
3. Албан шаардлагыг хэрэгжүүлж, биелэлтийг 2017 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн дотор Дундговь аймаг дахь Төрийн аудитын газарт хариу ирүүлэхийг Татварын хэлтсийн дарга М.Туяацэцэг, татварын улсын ахлах байцаагч Ж.Баярсайхан нарт хариуцуулав.



АЛБАН ШААРДЛАГЫГ

ЗӨВШӨӨРСӨН:

АУДИТОР  Д.ДОЛЖИНСҮРЭН

ДАРГА  М.ТУЯАЦЭЦЭГ
ТАТВАРЫН УЛСЫН
АХЛАХ БАЙЦААГЧ  Ж.БАЯРСАЙХАН

¹Албан шаардлагыг биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-т /Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтанг ажлаас халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ/

Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын
2017 оны 08 дугаар сарын 29 - ны өдрийн
01/70 дугаар албан шаардлагын хавсралт

4817144213
310A0039 9033475

Д/д	Байгууллагын нэр	Дэлгүүрийн нэр	Торгуулийн хэмжээ		Торгуулийн дүн /төгрөгөөр/
			Зөрчлийн нэгж	Нэгжийн үнэ	
1	Их жаст арвижих ХХК	Барилгын материалын дэлгүүр /Бүрд зоогийн газрын хойд талд/	1500	1000	1,500,000
2	Юүссаритү ХХК	Мөнгөлөг дэлгүүр	1500	1000	1,500,000
3	Буянт чандмань ХХК	Замбага дэлгүүр	1500	1000	1,500,000
4	Мандал хүрээ ХХК	Барилгын материалын дэлгүүр /Захын хажууд/	1500	1000	1,500,000
5	Дундговь хулд ХХК	Шашин болон барилгын материал /Захын урьд талд/	1500	1000	1,500,000
6	Сүүж Дөртөө Мандал ХХК	Соёмбо дэлгүүрийн хажуу	1500	1000	1,500,000
7	Арц Зандан ХХК	Барилгын материал /Мандал худалдааны төвийн хойд талд/	1500	1000	1,500,000
8	Их тойн ХХК	Шашин болон барилгын материал /Хүнсний 48 хойд талд/	1500	1000	1,500,000
	Нийт дүн				12,000,000